

“Онлайн курсын агуулга хөгжүүлэлт”



Нэг байгууллагаас 3 хүн нэгэн зэрэг суралцвал суралцагч бүрийн курсын төлбөрийг 5% хөнгөлнө.

Нэг суралцагч нэгээс илүү курст суралцвал 2 дахь курсээс эхлэн төлбөрийг 5% хөнгөлнө.

ОНЛАЙН СУРГАЛТЫН ЦОГЦ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИЦГЭЭ

Онлайн сургалтыг нэвтрүүлэхэд курс төлөвлөлт, агуулга хөгжүүлэлт, онлайн сургалтын технологи, багшлах арга зүй, онлайн сургалтын төслийн менежмент зэрэг цогц ур чадвар шаардагддаг. Үүний нэг бүрэлдэхүүн хэсэг болох “Онлайн курсын агуулга хөгжүүлэлт”-ийн үндсийг танилцуулахаар Цахим Мэдлэг кампусаас энэхүү курсыг эрхэм Суралцагч танаа өргөн барьж байна.



КУРС ЯМАР ЗОРИЛГОТОЙ ВЭ?

Онлайн сургалтыг хэрэгжүүлэх цогц чадамж олгох Цахим Мэдлэгийн багц сургалтын нэг бүрэлдэхүүн “Онлайн курсын агуулга хөгжүүлэлт” курс нь цахим сургалтын агуулгын нийтлэг хэлбэрүүдийг танилцуулж, хялбар ойлгомжтой агуулга бэлтгэх арга зам, ашиглагдах програм хангамжийн талаар мэдлэг олгож, агуулга бэлтгэх дадлага ур чадвар олгох зорилготой юм. Сургалтын агуулга боловсруулалт (Content Development) нь сургалтын холбогдох материалыг **цуглуулах**, эдгээрээс агуулгад ашиглах материалуудыг **сонгох**, агуулгыг курст тохируулан **зохион байгуулах**, эцэслэн

Курст суралцсанаар суралцагч:

- Цахим сургалтын агуулгын төрлүүд, эдгээрийг боловсруулах арга хэлбэрүүдийг судална.
- Агуулгыг суралцагчдад хялбар ойлгомжтойгоор боловсруулах, цахим сургалтын шинж төлөвт нийцүүлэн хэрхэн хэсэгчилж үзүүлэх талаар суралцана.
- Агуулгыг илүү харилцан ажиллагаатай (интерактив) болгох талаар суралцаж, хэрэгсүүдийг ашиглах чадвар эзэмшинэ.
- Цахим сургалтанд явцын шалгалтын ямар хэлбэрийг ашиглах нь боловсролын талаас илүү үр дүнтэй вэ?
- Онлайн курсын агуулга хөгжүүлэлтэнд ашиглагдах програм хангамжуудыг танилцуулах 2 өдрийн нүүр тулсан дадлагажуулах сургалтанд хамрагдаж, курсын цахим агуулга бэлтгэнэ.

Цахим Мэдлэг Кампус | mongolcampus.org 

Утас: 319367

Э-шуудан: info@mongolcampus.org

Вэб: www.mongolcampus.org/mek

ХЭРХЭН СУРАЛЦАХ ВЭ?

ХЭН СУРАЛЦАХ ВЭ?

Онлайн сургалт явуулах сонирхолтой их, дээд, дунд сургууль, МСҮТ-ийн багш нар; сургалтын агуулга бүхий сонирхсон байгууллага, хувь хүмүүсийг энэхүү сургалтанд урьж байна. Сургалтанд гадаадаас, орон нутгаас суралцаж болно.

Суралцагчид нь:

- Курсын агуулгын талаар маш сонирхолтой; бие даан суралцах, бусадтай онлайнаар харилцах, цагаа зөв зохицуулах чадвартай, хариуцлагатай;
- Компьютер, Интернэтийн хэрэглээний анхан шатны мэдлэгтэй; Интернэтийг тогтмол ашиглах боломжтой, мультимедиа хэрэгсэл бүхий компьютертэй;
- Байнга шалгадаг и-мэйл хаягтай байх шаардлагатай.

Курсыг амжилттай төгсөгчдөд Цахим Мэдлэг кампусаас **Сертификат** олгоно.

ЯМАР АРГААР СУРАЛЦАХ ВЭ?

Курс нь онлайнаар www.mongolcampus.org кампуст явагдах ба 2 долоо хоног үргэлжилнэ. Суралцагч 7 хоногт онлайнаар дор хаяж 10 цаг (өдөрт 2 цаг) буюу нийт 20 цаг, танхимын дадлагажуулах хичээлд 12 цаг зарцуулна. Сургалтын материалыг бие даан үзэж судална (сүлжээгүй орчинд байж болно). Суралцагч бүлгийн чат, хэлэлцүүлэгт оролцож сургалтын агуулгын талаар хэлэлцэнэ. Өөрийгөө сорих тест бөглөж, курсын даалгаврыг хийн багшаас хариу авна. Хөтөч багш суралцагчдыг дэмжин чиглүүлэх юм.

Суралцагч курсын эхэнд явагдах 3 цагийн танхимын сургалтанд ирж Цахим Мэдлэг кампуст онлайнаар хэрхэн суралцах талаар дадлага хийж болно. Түүнчлэн суралцагч Интернэт ашиглах боломжгүй үедээ Гарц сургалтын төвд (СБД, Хурд хотхоны 10А байрны 38 тоот) ирж Интернэт үнэгүй ашиглах боломж бий.

КУРС ХЭЗЭЭ ЯВАГДАХ, ХЭРХЭН БҮРТГҮҮЛЭХ ВЭ?

Сургалтын хуваарь Цахим Мэдлэг www.mongolcampus.org кампус дээр тавигдах ба тогтмол явагдана.

Курст элсэхийн тулд www.mongolcampus.org хаягаар орж бүртгүүлнэ. Курсын төлбөрийг Цахим Мэдлэг ТББ-ын Голомт банкин дахь 110 293 6629 дансанд шилжүүлэх буюу эсвэл



БИДНИЙ ДАВУУ ТАЛ

ЦАХИМ МЭДЛЭГ ГЭЖ ХЭН БЭ?

Цахим Мэдлэг бол мэдээлэл, холбооны технологийг мэдлэг түгээх хэрэгсэл болгон ашиглах, Монгол улсад онлайн сургалтыг нэвтрүүлэх, мэдлэгийн менежмент хийх зорилготой түншүүдийн санаачилгаар 2006 онд үүсгэн байгуулагдсан төрийн бус байгууллага юм. Бид GIZ Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн (ГОУХАН) e-Академитэй хамтран ажилладаг.



Цахим Мэдлэгийн хөтөч багш нар нь “Онлайн сургалтыг хөгжүүлэх ба хэрэгжүүлэх” урт хугацааны онлайн болон танхимын сургалтанд амжилттай оролцож, ГОУХАН болон Австрийн Теле-Академиас “Сургагч багш” мэргэжлийн сертификат авсан бөгөөд ГОУХАН-ийн Ази болон Төв Азийн онлайн сургалтын сүлжээнд багшилж ирсэн туршлагатай. Түүнчлэн Цахим Мэдлэг баг нь АНУ-ын Миссурийн их сургуулийн онлайн сургалтын экспертүүдийн зөвлөмж, дэмжлэгтэй ажиллаж байна.

ЦАХИМ МЭДЛЭГИЙН ОНЛАЙН СУРГАЛТ ЮУГААРАА ДАВУУ БӨГӨӨД ШИНЭЛЭГ ВЭ?

- Онлайн сургалтыг хэрхэн төлөвлөх, хэрэгжүүлэх сэдвээр 2009 оноос эхлэн Монголд явагдаж байгаа анхны сургалт
- Монгол хэл дээр, онлайн орчинд мэргэжлийн багш экспертүүдийн дэмжлэгтэй явагдана.
- Дэлхийн 222 оронд өргөнөөр ашиглагдаж байгаа Мүүдл сургалт удирдах системийг ашигласан.
- Нэг бүлэгт 15 хүртэл хүн суралцах тул багш оролцогч бүрийг дэмжих, тулж ажиллах боломжтой.
- Суралцагчид ажлын байр, гэр орон, хүссэн газраасаа боломжтой цагтаа өөрийн хэмнэлээр суралцана.
- Интернэт хэрэглэх боломжгүй үедээ суралцагч Гарц сургалтын төвд ирж Интернэт үнэгүй ашиглаж болно.
- Сургалтын агуулгыг татаж авснаас хойш Интернэтгүй орчинд үзэж судалж болно.
- Өөрийн байгууллагад онлайн сургалтыг нэвтрүүлэхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшиж, Сертификат авна.

Таныг цахим мэдлэгийн ертөнцөд урьж байна.

Цахим Мэдлэг Кампус | mongolcampus.org  **Цахим Мэдлэг Кампус**

Утас: 319367

Э-шуудан: info@mongolcampus.org

Вэб: www.mongolcampus.org/mek


ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

Дэмжигч байгууллагууд



“Онлайн курс төлөвлөлт”, “Онлайн курсын агуулга хөгжүүлэлт”, “Онлайн курст багшлах нь” багц курсын агуулгыг монгол хэлнээ шинэчлэн боловсруулж Монголын багш, боловсролын мэргэжилтнүүдийн хүртээл болгоход санхүүгийн тусламж үзүүлсэн АНУ-ын ЭСЯ-ны Ардчиллын Жижиг Тэтгэлэгт Хөтөлбөрт талархаж байгаагаа илэрхийлье.

Холбоо барих хаяг:



Цахим
Мэдлэг

Цахим Мэдлэг ТББ

СБД, 6-р хороо, Хурд хотхон, 10А байр, 38 тоот
Их сургуулийн гудамж 3/2, Улаанбаатар 14200, Монгол улс

Тел: 319367, 77339367, 99091156

Вэб: <http://www.mongolcampus.org/mek>

Э-шуудан: info@mongolcampus.org

СОНИРХУУЛАХАД

Өдгөө дэлхий даяар Blackboard, Sakai, Moodle, A Tutor зэрэг онлайн сургалт удирдах олон янзын системийг хэрэглэж байна.

Үүнээс зөвхөн Мүүдлийг ашигласан 54,094 кампус ажиллаж, тэнд нийт 222 орны 69.4 сая суралцагчид 7.8 сая хичээлийг шимтэн судалж байна. Энд хэлэлцүүлгийн тоо 140,7 сая, сургалтын материалын тоо 70,7 сая, сорилын асуултын тоо 304,3 саяд хүрсэн ажээ.

Мүүдл хэрэглэж байгаа топ 10 орныг АНУ, Испани, Бразил, Их Британи, Мексик, Герман тэргүүлж байна.

Эх үүсвэр:

Мүүдл СУС-ийн вэбсайт
<http://moodle.org/stats/>

Цахим Мэдлэг Кампус | mongolcampus.org



Утас: 319367

Э-шуудан: info@mongolcampus.org

Вэб: www.mongolcampus.org/mek